



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/360

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэг, 17.8.2, 17.8.3, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.30 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Баянмөнхийн хүсэлтийг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн гишүүний орон тоонд шалгуур шаардлага хангасан гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийг Чингэлтэйн нэгдсэн эмнэлэгийн захирал (Х.Ганцэцэг)-д, бүрэн эрхийн хугацааг баталгаажуулан ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан тус дүүргийн Засаг даргын 2025 оны “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталгаажуулах тухай” А/248 дугаар захирамжийн хавсралтын Б.Баянмөнхтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525011 93